

БАТЛАВ.

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ  
ХОРООНЫ ДАРГА  
Г.ЧИНЗОРИГ



ӨМГӨӨЛЛИЙН ШИЙЛД ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Г.ЦЭНГЭЛ



ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

2022 оны 05 дугаар  
сарын 12-ны өдөр

№ 1/2257

Улаанбаатар хот

Энэхүү “Эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ” (цаашид “Гэрээ” гэх)-г,

Нэг талаас Монгол улс, Сүхбаатар дүүрэг, Сүхбаатарын гудамж-13, Метро бизнес тов А-блок 5 давхар хаягтай **ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО** (цаашид “Үйлчлүүлэгч” гэх)-ийг төлөөлөн **Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газрын дарга З.ЭРДЭНЭЧУЛУУН,**

Ногоо талаас Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, 51-503 тоот хаягтай Өмгөөллийн шийлд ХХК /цаашид “Өмгөөлөгч” гэх/ нар /цаашид хамтад нь “Талууд” гэх/ нь Монгол Улсын Иргэний хууль болон Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Өмгөөллийн тухай хуулийн холбогдох зүйл заалт, гэрээнд оролцогч талуудын харилцан бие биедээ итгэл үзүүлж гаргасан хүсэлтүүдийг үндэслэн дор дурсан нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү Гэрээгээр Өмгөөлөгч нь Үйлчлүүлэгчийн дор дурдсан үйлчилгээ /Цаашид “Хуульчийн үйлчилгээ” гэх/-д Үйлчлүүлэгчид Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан зарим захиргааны хэм хэмжээний актын төсөл боловсруулах, санал өгөх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, эрх зүйн туслалцаа үзүүлэх Үйлчлүүлэгч нь Өмгөөлөгчид харилцан тохиролцсон Хуульчийн үйлчилгээний хөлс төлөхтэй холбоотой харилцаанд Талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг зохицуулна. Үүнд:
  - 1.1.1. Цахим хуудас хөтлөх, ил тод, нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журмын төсөл;
  - 1.1.2. Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журмын төсөл.
- 1.2. Үйлчлүүлэгч тал нь өмгөөлөгчийг сайн дурын үндсэн дээр сонгосон бөгөөд Өмгөөлөгчийн зүгээс энэхүү сонголтод гагцхүү хөндлөнгийн байр суурь илэрхийлсэн болно. Үйлчлүүлэгч талаас сонголт хийх үйл явцад аливаа хэлбэрээр хөндлөнгөөс оролцоогүй, өмгөөлөгч сонгох цар хүрээг хязгаарлах гэж оролдоогүй болно.
- 1.3. Өмгөөлөгч нь Үйлчлүүлэгчид урьдчилан амлалт өгөхгүй, ямар нэгэн үр дүн амлаагүй бөгөөд үр дүн амлахыг хуулиар хориглодог болно. Хэрэв Өмгөөлөгчийн зүгээс



Үйлчлүүлэгч талд үр дүн амласны үндсэн дээр энэхүү гэрээг байгуулах үндэслэл боллоо гэж Үйлчлүүлэгч тал үзэж байгаа бол энэхүү гэрээг байгуулахаас тагталзаж, өөр өмгөөлөгчид хандах эрхтэй ба хэрэв гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан бол Өмгөөлөгчийн зүгээс амлалт өгөөгүй, үр дүн амлаагүйг, мөн цаашид амлахгүйг хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ.

- 1.4. Үйлчлүүлэгч нь Өмгөөлөгч, түүний туслах ажилтнаас хуульд нийцэхгүй шаардлага тавих эсвэл хууль зөрчихийг шаардах эрхгүй болохыг Талууд үүгээр баталгаажуулав.

### Хоёр. Талуудын эрх, үүрэг

- 2.1. Өмгөөлөгч нь дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:
- 2.1.1 Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ ямар нэгэн нөлөөнд автахгүйгээр, эрх зүйн ухамсар, мэргэжлийн үүргээ удирдлага болгох эрхтэй;
  - 2.1.2 Хууль зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдсон баримт бичгийн төсөл, мэдээлэл, нотлох баримтуудыг Үйлчлүүлэгчээс шаардан гаргуулан авах эрхтэй;
  - 2.1.3 Хууль зүйн туслалцаа үзүүлсний төлөө гэрээгээр тохиролцсон хөлс авах эрхтэй;
  - 2.1.4 Ашиг сонирхлын зөрчил болон хараат байдалд оруулахуйц харилцаа холбооноос зайлсхийх, бусдын хууль бус шаардлагыг биелүүлэхээс тагталзах эрхтэй;
  - 2.1.5 Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.3.1-34.3.19 дүгээр зүйлд заасан эрх эдлэнэ;
  - 2.1.6 Хууль зүйн туслалцаа үзүүлж буй ажиллагааны явцад олж мэдсэн Үйлчлүүлэгчийн нууцыг задруулахгүй байх, эсрэг ашиглахгүй байх үүрэгтэй бөгөөд энэхүү үүрэг нь Өмгөөллийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6 дугаар заалтад хамаарахгүй болно.
  - 2.1.7 Үйлчлүүлэгчид хуулийн хүрээнд хангалттай хэмжээгээр үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй;
  - 2.1.8 Өмгөөлөгч нь Үйлчлүүлэгчийнхээ хууль ёсны эрх ашгийг зөрчсөн санаагай аливаа хууль бус үйлдэл хийхгүй байх үүрэгтэй;
  - 2.1.9 Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4.1-34.4.6 дугаар зүйлд заасан үүрэг хүлээнэ.
  - 2.1.10 Өмгөөллийн үйлчилгээнд өөрийн хуулийн фирмийн туслах ажилтанг оролцуулах эрхтэй.
  - 2.1.11 Хууль болон гэрээнд заасан бусад эрх, үүрэг.
- 2.2. Үйлчлүүлэгч нь дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:
- 2.2.1 Гэрээнд заасан үйлчилгээг Өмгөөлөгчөөс авах эрхтэй;
  - 2.2.2 Өмгөөлөгчийн боловсруулсан баримт бичгийн төсөл, хууль зүйн зөвлөгөө, мэдээлэлтэй танилцах;
  - 2.2.3 Өмгөөлөгч, түүний туслах ажилтанг шаардлагатай мэдээллээр хангах, нотлох баримтыг хүлээлгэн өгөх;
  - 2.2.4 Хууль зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдох байгууллагаас шалтгаалах бүхий л бололцоогоор хангах /шаардлагатай тохиолдолд боловсруулсан эрх зүйн баримт бичгийг өөрийн албан маягт дээр цаг алдалгүй хэвлэх, батлах, нотлох баримт гаргах, шинжээчийн зардлыг хариуцах г.м/ үүрэгтэй;
  - 2.2.5 Гэрээгээр тохиролцсон үйлчилгээний хөлс, зардлыг гэрээнд заасны дагуу төлөх үүрэгтэй;
  - 2.2.6 Өмгөөлөгчийн хуулийн хүрээнд өгсөн зөвлөгөө болон тавьсан шаардлагыг цаг тухайд нь биелүүлэх, биелүүлээгүйгээс учирсан гэм хорыг өөрөө хариуцах үүрэгтэй;
  - 2.2.7 Өмгөөлөгчийг үнэн зөв мэдээллээр хангах, үйлчлүүлэгчийн зүгээс гаргаж өгсөн нотлох баримт нь хууль бус, хуулийн шаардлага хангаагүйгээс үүсэх бүх хууль зүйн үр дагавар, хариуцлагыг Үйлчлүүлэгч бүрэн хариуцах үүрэгтэй;



- 2.2.8 Өмгөөлөгчид хууль бус шаардлага тавихгүй байх, хууль зөрчсөн алиаа үйл ажиллагаанд уриалахгүй байх үүрэгтэй;
- 2.2.9 Хууль зүйн туслалцаа үзүүлэхтэй холбоотой гарах зайлшгүй зардал (Шүүхийн тэмдэгтийн хураамж, нотариатын зардал гэх мэт)-ыг бүрэн хариуцаж гаргах үүрэгтэй;
- 2.2.10 Өмгөөлөгчтэй харилцах шаардлага үүссэн боловч өмгөөлөгчтэй холбогдох боломжгүй бол өмгөөлөгчийн туслэх ажилтантай холбогдох,
- 2.2.11 Хууль болон гэрээнд заасан бусад эрх, үүрэг.

### **Гурав. Үйлчилгээ хөлс, хөлс төлөх журам**

- 3.1. Өмгөөлөгчийн үйлчилгээний хөлс нийт 9,200,000 /есөн сая хоёр зуун мянга/ төгрөг бөгөөд өмгөөлөгчийн Голомт банкны 1415114336 тоот дансанд гэрээ байгуулсан өдөр төлнө. Энэхүү үнийн дүнд НӨАТ багтаагүй болно.
- 3.2. Өмгөөлөгч талын зүгээс өмгөөллийн үйлчилгээг аливаа хэлбэр (материал судлах, бэлтгэх, баримт бичиг боловсруулах, шүүх, хуулийн байгууллагад хандах зэрэг аль аль нь хамаарна)-ээр эхлүүлсний дараагаар үйлчлүүлэгч талын зүгээс гэрээг цуцлах саналыг тавьсан нөхцөлд өмгөөллийн үйлчилгээ үзүүлж байсан гэж тооцох бөгөөд энэ нөхцөлд үйлчлүүлэгч талын төлсөн төлбөрийг буцаан олгохгүй байхаар харилцан тохиролцов.
- 3.3. Гэрээ байгуулах үед энэхүү гэрээний 3.2-г заасан нөхцөлийг үйлчлүүлэгч талын зүгээс хүлээн зөвшөөрөхгүй байгаа нөхцөлд энэхүү гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулахаас татгалзаж, өөр өмгөөлөгчид хандаж болох ба энэхүү эрхийг өмгөөлөгчийн зүгээс хязгаарлаагүй болно. Хэрэв гарын үсэг зурсан бол 3.2 дах заалтыг хүлээн зөвшөөрсөнд тооцно.
- 3.4. Үйлчлүүлэгч талын зүгээс гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан хэдий ч өмгөөллийн төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй нөхцөлд өмгөөлөгчийн зүгээс мөн үүргээ гүйцэтгэхээс татгалзах эрхтэй болно.

### **Дөрөв. Гэрээний хугацаа**

- 4.1. Энэхүү гэрээ нь Талуудын эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурснаар хүчинтэй болох ба үйлчлүүлэгч талын зүгээс өмгөөллийн төлбөрөө төлсөн өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлнэ. Өмгөөлөгч нь гэрээт ажлыг 7 хоногийн хугацаанд багтаан дуусган хүлээлгэн өгнө.
- 4.2. Хэрэв үйлчлүүлэгч тал өмгөөлөгчөөс татгалзаж, гэрээг цуцлах санал гаргасан бол мөн гэрээ дуусгавар болно.

### **Тав. Маргаан шийдвэрлэх**

- 5.1. Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэх явцад аливаа маргаан үүсвэл Талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Харилцан тохиролцож чадаагүй тохиолдолд Монгол Улсын шүүхээр асуудлыг шийдвэрлүүлнэ.

### **Зургаа. Гэрээ цуцлах, дуусгавар болох**

- 6.1. Гэрээг дараах үндэслэлээр цуцалж болно. Үүнд:
- 6.2.1. Үйлчлүүлэгч талын зүгээс хэдийд ч өмгөөлөгчөөс татгалзаж, хугацаанаас өмнө энэхүү гэрээг цуцалж болно.
- 6.2. Гэрээний хугацаа дууссан, эсвэл гэрээг гэрээний аль нэг тал хууль болон гэрээнд заасан үндэслэлээр гэрээг цуцалсан нөхцөлд энэхүү гэрээ дуусгавар болно.

### **Долоо. Бусад зүйл**



- 7.1. Талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахаар санал гаргах эрхтэй бөгөөд нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж, Талуудын эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурсанаар хүчин төгөлдөр болно.
- 7.2. Нэмэлт, өөрчлөлт нь энэхүү Гэрээний салшгүй нэг хэсэг байна.
- 7.3. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж, баталгаажуулах бөгөөд тал тус бүр нэг, нэг хувийг хадгалана. Талуудад хадгалагдаж буй хувь хууль зүйн адил хүчинтэй байна.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

Үйлчлүүлэгч:



**ХХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН  
Б.НЯМДУЛАМ**

Өмгөөлөгч:

